

6 COVID-19 ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРЭГ COVID-19 ӨВЧНИЙ ТАЛААР ЯРИХ

Ярилцах хүсэлтэй бай. Тэд хэдийн мэдээлэл сонссон байгаа. Чимээгүй байж, нууж хааснаар та хүүхдүүдээ хамгаалж чадахгүй. Харин шударга, нээлттэй байх хэрэгтэй. Тэд хэр ихийг ойлгож чадахыг бодож тооцоол. Та тэднийг хамгийн сайн мэднэ шүү дээ!

Нээлттэй байж, сонс

Хүүхдүүдээ чөлөөтэй ярихыг зөвшөөр. Тэднээс асуулт асууж, хэр ихийг мэдэж байгааг нь тодорхойл.

Шударга бай

Тэдний асуултад үргэлж үнэн хариулт өг. Хүүхдүүд тань хэдэн настай билээ, хэр ихийг ойлгож чадахыг тооц.

Дэмжигч бай

Хүүхэд тань айж, балмагдсан байж магад. Тэдэнд мэдрэмжээ хуваалцах орон зай өгч, тэдний төлөө гэдгээ мэдүүл.

Маш их мэдээлэл тархаж байна.

Зарим мэдээлэл буруу ташаа байж болох юм. Дараах баталгаат эх сурвалжуудыг ашиглаарай: <https://www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/advice-for-public> and <https://www.unicef.org/coronavirus/covid-19> from WHO and UNICEF

Танд хариулт байхгүй байсан ч зүгээр.

«Би мэдэхгүй байна. Гэхдээ олж мэдэхээр хичээж байна» эсвэл «би мэдэхгүй байна. Гэхдээ энэ талаар бодно» гэж хариулж болно. Энэ бол хүүхэдтэйгээ хамт шинийг сурах боломж юм!

Баатрууд дээрэлхүү байдаггүй.

COVID-19 өвчин хүмүүсийг гадаад төрх, гарал үүсэл, ямар хэлээр ярьдгаар нь ялгагдаггүй. Өвдсөн хүмүүс болон тэднийг асран сувилж байгаа хүмүүст сайхан сэтгэлээр хандах ёстойг заах нь зөв. Өвчтэй хүмүүсийг халамжилж, өвчний дэгдэлтийг зогсоохын төлөө ажиллаж буй хүмүүсийг тухай ярьж өг.

Яриагаа сайн мэдээллээр өндөрлө

Хүүхэд тань зүгээр эсэхийг шалга. Тэдэнд санаа тавьж, хэзээ ч сонсоход бэлэн гэдгээ хэл. Тэгээд хамтдаа ямар нэг хөгжилтэй зүйл хий!

